



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 07 өдөр

Дугаар Б/37

Ховд

Д.Энхболдыг өөр ажилд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.20, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.3, дугаар зүйлийн 43.3.2-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийг нэгж болгон өөрчлөхтэй холбогдуулан Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Дашзэвэгийн Энхболдыг тус албан тушаалаас чөлөөлж, өөрийнх нь хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01/2127 дугаартай албан бичгийг үндэслэн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн даргаар 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн шилжүүлэн ажиллуулсугай.

2. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргын албан тушаалын тодорхойлолтыг батлуулж ажиллахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Отгоншигт үүрэг болгосугай.

3. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

4. Засаг даргын Тамгын газрын даргын сул орон тоо нөхөгдөх хүртэл хугацаанд уг албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баярсүх, санхүүгийн холбогдох тооцоо хийж Д.Энхболдод хуульд заасан цалин хөлс тооцож олгохыг ерөнхий нягтлан бодогч Б.Нямдэлгэр нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.БОЛОРМАА

8400 01 3053

Zah B/37 am

Аймгийн Засаг даргын 2022 оны  
19 дүгээр сөрөг 17-ны өдрийн  
Б/37 дугаар захиралын хавсралт



## АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Багдал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүн: Н.Ганзориг (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Нарийн бичиг: Б.Энхмандал (Санхүү, аж ахуйн тасгийн нягтлан  
бодогч)

-оОо-